

Израилийн Кнессет буюу парламентын 19 дэх удаагийн сонгууль энэ сарын 22-нд болж онгорлоо. Тус улсын Сонгуулийн хорооноос ялагчийг зарласан байна.

Сонгуульд Еронхий сайд Беньямин Нетаньяхугийн тэргүүлдэг Ликуд бвлэг ба Израиль бидний орон намаас бүрдсэн улс торийн эвсэл нийт сонгогчдын 23.25 хувийн санал авч парламентын 120 суудлаас 31-ийг авснаар эвслийн засгийн газар байгуулах эрхтэй боллоо.

Энэхүү үзүүлэлт нь Еронхий сайдын тэргүүлсэн эвслийн тосоолсноос нэлээд доогуур үр дүн юм. Тэд 19 суудал авсан Йеш Атид, 15 суудал авсан эрх зүйн намтай хамтран эвслийн засгийн газар байгуулна. Ингэснээр Беньямин Нетаньяхугийн хувьд засгийн газраа эмхлэн байгуулахад багагви хвндрэлтэй болсон байна.

Олон улсын ажиглагчдын ярьснаар шинэ нам хвчнүүд энэ удаагийн сонгуульд нэлээд амжилттай оролцсон нь израильчуудыг хуучин нам хвчнээс залхсаныг харуулж байгаа аж. Беньямин Нетаньяхугийн хувьд улс орныхоо тогтвортой байдлыг хангаж, онгорсон жилүүдэд хэрэгжүүлсэн цэрэг стратегийн бодлогоо цаашид үргэлжлүүлж, Ираны болзошгви аюулаас сэргийлэхийг хвсэж байгаа юм.

Беньямин Нетаньяху засгийн эрхэнд гарах бвр Израиль Палестины харилцаа мууддаг талтай. Тэрээр Палестины тусгаар улсын талаарх толовлогоог хвлээн зовшоорохоос татгалздаг богоод нилээд хатуу байр суурь баримталдаг юм.

Ирэх жилүүдэд Израиль Палестины харилцаа улам бвр муудах толов харагдаж байна.